



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 0788

Улаанбаатар хот

Мал, амьтны зарим халдварт өвчнөөс
урьдчилан сэргийлэх, хорогдсон мал, амьтны
сэг зэм цуглуулж устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2.2.1 дэх дэд заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/34 дүгээр тушаал, Нийслэлийн Онцгой комиссын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/348 дугаар захирамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын 2023 оны А/21 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт мал, амьтны халдварт, гоц халдварт, шимгэгч өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Мал, амьтны зарим халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн үйл ажиллагааг чанар үр дүнтэй хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ трейд" ХХК (А.Цэрэндагва)-д, сэг зэмийн устгалын ажлыг зохион байгуулахад шаардлагатай машин техникээр хангаж ажиллахыг "Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ОНӨААТҮГ (Ч.Батхуяг)-т., "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа)-д, тус ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Я.Батсүх)-т тус тус үүрэг болгосугай.

3. Мал, амьтны сэг зэм цуглуулж устгах, халдваргүйтгэл хийх арга хэмжээ зохион байгуулахад зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

4. Шаардагдах 1,161,860 (Нэг сая нэг зуун жаран нэгэн мянга найман зуун жаран) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Дүүргийн онцгой байдлын хэлтсийн дарга (Б.Цогбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 01 дугаар сарын 01-ны өдрийн
А/ХХ дугаар захирамжийн хавсралт

МАЛ, АМЬТНЫ ЗАРИМ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ХОРОГДСОН МАЛ, АМЬТНЫ СЭГ ЗЭМ ЦУГЛУУЛЖ УСТГАХ ТУХАЙ

№	Хийгдэх ажил	Зардлын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1.	Орчны цэвэрлэгээ болон үхсэн малын сэгийг устгахад шаардагдах халдваргүйтгэлийн бодис	Суперкил	кг	1	33000	33.000
		Хлорын шохой	кг	50	8000	400.000
2.	Сэг зэмийн тархацыг судлах, хяналт хийхэд шаардагдах шатахуун	АИ-92	литр	24	2390	57.360
3.	Сэг зэмийг цуглуулахад шаардагдах шатахуун (3 өдрийн)	Дизель түлш	литр	80	3700	296.000
	Сэг зэм устгах нүх ухах, дарж булахад шаардагдах шатахуун	Дизель түлш	литр	35	3700	129.500
4.	Хөдөлмөр хамгааллын хувцас	Ажлын бээлий	ширхэг	10	3000	30.000
6.	Өдрийн хоол	3 өдөр 6 хүн	Хүн/өдөр	18	12000	216.000
		Нийт				1.161.860